

Монгол Улсын Засгийн газар COVID-19-ийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс эрчимтэй авч эхэлсэн. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг 1-р сарын 27-ноос эхлэн албан ёсоор зогсоож, коронавирусын халдвар илэрсэн улсууд руу зорчих аялалын хориг тавьсан төдийгүй 2-р сарын 13-нд Монгол улс онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. Мөн 2020 оны 2-р сарын 24-26-ний өдрүүдэд тохиосон Сар шинийн баярын үеэр коронавирусын халдвар гарах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой Комиссоос хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хориглох шийдвэр гаргасан. Нийслэл Улаанбаатар хот хүн амын төвлөрөл ихтэй, Монгол улсын нийт хүн амын тэн хагас нь оршин суудаг. Үүгээр зогсохгүй, Улаанбаатар хотоор дамжин зорчих хөдөлгөөн их тул коронавирусын халдварыг улс даяар тараах эрсдлийн хамгийн том хүчин зүйлсийн нэг болж байна. Эрсдлийн бэлэн байдлыг цаг ямагт хангаж, коронавирус илэрсэн үед авах арга хэмжээг чанаржуулахын тулд, иргэдийн орж, гарах урсгалын талаарх бүртгэл мэдээллийг сайжруулах ажлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ), Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын Монгол дахь салбарын техник туслалцаатайгаар хэрэгжүүлж байна. НЗДТГ болон ОУШХБ-ын хамтын ажиллагааны дагуу мэдээлэл цуглуулах ажилд 400 гаруй эмнэлгийн болон боловсролын салбарын ажилтныг дайчлан хамруулж, ДТМ аргачлалд сурган, хэрэгцээт зөвлөмж, техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна. Хот хоорондын хөдөлгөөн хязгаарлалттай үед буюу 2-р сарын 27-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл урсгал хөдөлгөөнийг хянах ажлын туршилтын үе хийгдэж, үүнээс хойш 6-р сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжилнэ. Нийслэлийн ойролцоох 6 (**Эмээлт, Баруунтуруун, Гүнт, Өлзийт, Морин, Налайх**) шалган нэвтрүүлэх товчоод дээр тээврийн хэрэгслийн төрөл, зорчигчдын тоо, хүйс, зорчин явж буй чиглэлийн талаарх мэдээллийг 24 цагийн турш иргэдээс авч байна. Хэдийгээр ДТМ аргачлалыг нийслэл хотод анх удаа ашиглаж байгаа боловч дэлхийн 80 гаруй улсад онц байдлын үед ашигладаг ба зөвхөн 2018 онд л гэхэд 40 сая гаруй хүнийг хамруулжээ. Мөн 2018 онд Өмнөд Судан улсад Эбола вирус тархах үеэр иргэдийн хөдөлгөөнийг тандах зорилгоор ДТМ аргачлалыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Монгол улсын хувьд Онцгой Байдлын Ерөнхий Газар, ОУШХБ хамтран 2018 оноос хойш 21 аймаг, 330 сумд дахь иргэдийн хөдөлгөөнийг баримжаалан тандаж байгалийн гамшиг, тэр дундаа зудын нөхцөл үүссэн үед ажиллах бэлтгэл ажлыг хангах зорилгоор уг аргачлалыг хэрэглэж ирсэн.

ТОЙМ ТОО

2,696,177

Хөдөлгөөний нэмэгдсэн дүн ДТМ (УХЦ)
урсгал хянасан хөдөлгөөний цэгээр хянасан.

37,029 ↑

Сүүлийн 24 цагт
бүртгэгдсэн хөдөлгөөн

10,805 (X)

43,111 (Ч)

Зорчих хөдөлгөөн хориотой (X) болон
чөлөөтэй (Ч) үеийн өдрийн дундаж хөдөлгөөн

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

52%

53%



ЭМЭГТЭЙ

31%

32%



ХҮҮ

9%

9%




ОХИН


7%

6%

ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨН (НИЙТ)



ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГЛЭЛ




ТОВЧООД ДЭЭРХ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ

Товчоо	НИЙТ			2020-5-8		
	НИЙТ	Орсон	Гарсан	НИЙТ	Орсон	Гарсан
Баруунтуруун	402,017	191,320	210,697	0	0	0
Өлзийт	391,105	204,898	186,207	4,310	2,994	1,316
Налайх	806,464	402,558	403,906	14,117	6,252	7,865
Морин	627,433	313,641	313,792	13,145	6,580	6,565
Эмээлт	946,890	508,282	438,608	11,985	4,009	7,976
Гүнт	490,643	246,115	244,528	5,562	3,038	2,524
НИЙТ	3,664,552	1,866,814	1,797,738	49,119	22,873	26,246




УЛААНБААТАР РУУ ЧИГЛЭСЭН ХӨДӨЛГӨӨН






Legend

УБ-т очих дүүрэг



Гарсан аймаг



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

52%

55%



ЭМЭГТЭЙ

31

31%



ХҮҮ

9%

8%




ОХИН

7%

6%


Улаанбаатарт очсон дүүрэг	?	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Улаанбаатар	5,590	13,673	38,055	57,650	116,598	47,160	302,731	61,702	287,321	38,955	969,435
Архангай	197	27	68	7,632	9,584	3,232	4,697	194	15,807	2,614	44,052
Баянхонгор	118	25	55	2,902	4,373	1,456	2,284	182	8,438	1,528	21,361
Баян-Өлгий	23	5	1	395	706	121	152	48	1,233	242	2,926
Булган	216	27	70	6,016	8,002	2,458	4,269	124	10,729	2,131	34,042
Дархан-Уул	295	50	145	8,484	10,433	2,877	6,101	359	23,344	3,458	55,546
Дорнод	132	37	16	1,631	8,232	1,077	1,831	134	1,818	1,350	16,258
Дорноговь	385	45	103	5,416	12,119	1,648	3,747	460	3,760	2,425	30,108
Дундговь	192	22	97	4,230	10,414	1,674	5,348	187	5,289	2,162	29,615
Говь-Алтай	48	24	36	1,122	2,006	526	901	38	4,147	565	9,413
Говьсүмбэр	317	25	145	3,122	11,335	924	2,138	436	2,074	1,554	22,070
Хэнтий	292	49	34	3,872	23,396	2,221	3,659	493	3,745	3,003	40,764
Хөвд	14	2	12	967	1,734	400	984	52	4,457	378	9,000
Хөвсгөл	123	35	102	3,797	5,357	1,580	2,665	131	8,764	1,655	24,209
Орхон	193	5	130	7,755	8,694	1,929	5,587	232	12,153	2,645	39,323
Сэлэнгэ	198	46	207	12,226	12,196	3,651	6,219	408	13,848	3,734	52,733
Сүхбаатар	96	43	48	1,225	7,600	729	1,130	160	1,171	1,050	13,252
Төв	2,048	293	1,145	49,947	72,052	22,670	58,010	9,473	93,412	24,255	333,305
Өмнөговь	185	11	145	5,454	9,912	1,825	9,779	249	8,764	2,533	38,857
Өвөрхангай	260	63	141	7,426	10,615	2,904	6,670	268	19,839	2,798	50,984
Завхан	75	18	29	2,325	3,892	868	1,630	80	5,192	1,078	15,187
Увс	38	8	21	1,121	2,182	514	1,004	99	4,239	450	9,676
?	89	15	371	579	1,445	190	743	414	957	341	5,144
НИЙТ	11,124	14,548	41,176	195,294	352,877	102,634	432,279	75,923	540,501	100,904	1,867,260

УЛААНБААТАРААС ГАРСАН ХӨДӨЛГӨӨН




Legend


Очиж буй аймаг



УБ-аас гарсан дүүрэг



Улсын хил
 Гол зам



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

52%

50%



ЭМЭГТЭЙ

30%

32%



ХҮҮ

10%

10%



ОХИН

8%

7%

Улаанбаатараас гарсан дүүрэг	?	Багахангай	Баянзүрх	Багануур	Баянгол	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Арханагай	386	48	7,619	82	5,481	2,518	3,786	180	13,528	2,267	35,895
Баянхонгор	117	23	3,293	93	2,508	1,101	2,008	126	7,925	1,222	18,416
Баян-Өлгий	2	-	669	-	431	119	164	24	1,028	158	2,595
Булган	294	1	6,303	52	4,808	2,030	3,380	65	9,484	1,754	28,171
Дархан-Уул	209	35	8,991	136	7,259	2,700	5,402	358	26,477	3,349	54,916
Дорнод	150	23	9,596	28	1,682	1,035	1,848	244	1,652	1,360	17,618
Дорноговь	397	18	13,414	223	5,700	1,972	4,347	368	3,913	2,292	32,644
Дундговь	140	20	10,205	103	3,787	1,567	5,307	150	5,719	2,301	29,299
Говь-Алтай	31	9	1,541	47	791	427	795	84	4,093	413	8,231
Говьсүмбэр	244	24	10,616	111	2,727	965	2,039	381	1,935	1,184	20,226
Хэнтий	316	58	23,841	66	3,703	1,983	3,318	444	3,247	2,836	39,812
Ховд	31	3	1,455	15	821	272	728	57	3,370	361	7,113
Хөвсгөл	98	11	4,020	38	2,506	1,094	2,112	75	8,160	1,202	19,316
Орхон	188	13	6,977	139	6,538	1,896	4,777	193	13,046	2,167	35,934
Сэлэнгэ	142	24	10,447	229	11,079	3,294	5,567	492	14,681	3,367	49,322
Сүхбаатар	130	27	8,239	58	1,099	706	1,246	98	1,207	1,244	14,054
Төв	1,734	215	67,674	1,179	44,178	20,883	52,358	8,454	87,176	22,123	305,974
Өмнөговь	116	33	10,974	191	5,611	2,339	10,073	275	9,195	3,220	42,027
Увс	57	8	1,632	25	860	398	830	47	3,238	479	7,574
Өвөрхангай	253	49	7,759	127	6,001	2,249	5,199	152	16,940	2,350	41,079
Завхан	70	17	2,953	29	1,777	693	1,383	107	5,103	699	12,831
?	326	30	1,324	103	563	269	1,133	567	1,178	377	5,870
НИЙТ	5,431	689	219,542	3,074	119,910	50,510	117,800	12,941	242,295	56,725	828,917